

Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн Г.АРИУНТУЯАГИЙН

2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт			Үнэлгээ
		Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин 4-р улирал	Хүрсэн түвшин / Биелэлт	
1	2	3	4	5	
Зорилт 1. Орчны эрүүл мэндийн талаар иргэд, байгууллага, хамт олны мэдлэгийг дээшлүүлэн, орчны эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулж, орчны эрүүл мэндийг сайжруулах					
1	Арга хэмжээ №1.1. 19 суманд MNS 5924:2015 стандартын нүхэн жорлонтой албан байгууллагын судалгааг гаргах, тоог нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Судалгаатай болох, тоог нэмэгдүүлэх	Стандартын нүхэн жорлонтой байгууллагын тоог нэмэгдүүлсэн тайлан гаргасан байна	ЭМГ-ын даргын 04/575 тоот албан бичгээр стандартын нүхэн жорлонтой болгох үйл ажиллагааг зохион байгуулах ажлын зөвлөмжийг хүргүүлсэн. Судалгаа, тайланг 7-р сарын 20-нд авч, нэгтгэсэн. Нийт 6 сумын албан байгууллага – 8, нийтийн ариун цэврийн байгууламж – 2, айл өрх – 207 стандартын нүхэн жорлонтой болсон.	100

					
2	Арга хэмжээ №1.2. Орчны эрүүл мэндийн чиглэлээр иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Сургалтын тоо Сурталчилгааны тоо	Сургалтын тоо – 2 Сурталчилгааны тоо – 4	Эрдэнэбулган сумын 1-р цэцэрлэгийн нийт 21 багш албан хаагчдад агаарын бохирдол, дотоод орчны бохирдол сэдэвт сургалтыг зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлсэн. Мөн Эрдэнэбулган сумын 15 цэцэрлэгийн нийт 80 гаруй туслах багш, үйлчлэгч нарт цэвэрлэгээ үйлчилгээ хийх заавар, халдваргүйтэлийн бодис хэрэглэх талаар сургалт зохион байгуулсан. Чулуут сумын 30 иргэнд Ундны усны эрүүл ахуйн талаар мэдлэг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.	100

3	Арга хэмжээ № 1.3. Аймгийн төвийн цэвэр усны нэгдсэн системд усыг хлоржуулах төхөөрөмж суурилуулж, халдваргүйжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэлээр холбогдох байгууллага, албан тушаалтанд нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	Үйл ажиллагааг зохион байгуулсан тайлан	Үйл ажиллагааг зохион байгуулж тайлагнасан байна	Ар Ус Ундарга ХХК, Цэнхэр сумын ЗДТГ, Хашаат сумын ЗДТГ-ын харьяа ундны усны хүдгуудад ЭМЯ-тай хамтран хяналт шалгалтыг хийж, албан шаардлага хүргүүлсэн. Аймгийн төвийн цэвэр усны нэгдсэн системд халдваргүйжүүлэх төхөөрөмжийг улсын төсвөөс суурилуулж байна. Ар Ус Ундарга компаний удирдлагууд, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 4 төлөөлөлтэй хамтарсан уулзалтыг зохион байгуулж, хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчил, цаашид анхаарах асуудал дээр санал солилцож, цаашид хийх ажлын төлөвлөлтийг хийсэн.	100
4	Арга хэмжээ № 1.4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудад ус, орчны эрүүл ахуйн нөхцлийн үнэлгээ хийх аргачлалын сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан ЭМБ-ын тоо	22	НЭМҮТ-ийн Орчны эрүүл мэндийн албатай хамтран 12-р сард зохион байгуулахаар төлөвлөсөн боловч цаг үеийн байдалтай холбоотой 2025 онд зохион байгуулахаар хойшлуулсан.	60
5	Арга хэмжээ №1.5. Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар сургалт сурталчилгааг зохион байгуулах	Цахим сурталчилгааны 4 төрлийн постер бэлтгэж, цахимаар түгээсэн байна. Зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо	Цахим сурталчилгааны 4 төрлийн постер цахимаар түгээсэн байна.	Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар НЭМҮТ-өөс гаргасан 4 төрлийн постерийг ЭМГ-ын цахим хуудсанд байрлуулан олон нийтэд түгээсэн. ТТӨ-өөс сэргийлэх сургалтыг НЭ, сүм, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч, мэргэжилтнүүдэд зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлсэн.	100

6	Арга хэмжээ №1.6. Боловсролын байгууллагын орчны эрүүл ахуй, хүүхдэд зэлтэй, аюулгүй байдалд үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангах	Үнэлгээ хийсэн байгууллагын тоо Зөвлөмж хүргүүлсэн хувь	20 100%	ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Эрдэнэбулган сумын хүүхдийн 15 цэцэрлэгийн цэвэрлэгээ үйлчилгээ, хоол үйлдвэрлэлийн байдалд хяналт үнэлгээг хийж, зөвлөмжийг цэцэрлэгт тус бүрээр гаргаж, Боловсролын газарт хүргүүлсэн.	
7	Арга хэмжээ №1.7. Эрдэнэбулган сумын Ерөнхий боловсролын сургуулийн орчин, аюулгүй байдлын судалгаа хийх, үр дүнг танилцуулах	Судалгаа хийсэн сургуулийн тоо Судалгааны тайлангийн уулзалт зохион байгуулсан байх	5 Тийм	ЭМГ-ын даргын 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн баталсан удирдамжийн дагуу Эрдэнэбулган сумын 5 ерөнхий боловсролын сургуулийн нийт 100 сурагчаас орчин, аюулгүй байдлын судалгааг авсан. Судалгааг нэгтгэн, боловсруулалт хийгдэж байна.	90
8	Арга хэмжээ №1.8. Ерөнхий боловсролын сургуулиудад “Гарын шингэн саван” хандивлах аян зохион байгуулах	Аяныг зохион байгуулах удирдамж боловсруулан хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна.	Аяны удирдамжийг боловсруулан, удирдамжийн дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байна	ЭМГ-ын даргын 2024 оны 99 тоот тушаалын дагуу ЭМБ-ууд Ерөнхий боловсролын сургуулиудад саван хандивлах аян зохион байгуулж, нийт 8 эрүүл мэндийн байгууллага 74 ширхэг гарын шингэн саван харьяа сургуулиудад хандивласан.	100

			    	
--	--	--	--	--

Зорилт 2. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх, халдварын сэргийлэлт, хяналт
ыг сайжруулах

9	Арга хэмжээ № 2.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр ЭМБ-уудын ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх цахим сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан ЭМБ-ын тоо	22	ЭМГ-ын даргын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 04/943 тоот албан бичгээр Эрүүл мэндийн байгууллагуудын ХСХ-ын багийн гишүүдэд нийт 54 эмч, мэргэжилтнүүдийг хамруулсан сургалтыг зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлсэн.	100
10	Арга хэмжээ №2.2. Сумын эрүүл мэндийн төвүүдийн ариутгач нарыг сургалтанд хамруулах	Сургалтанд хамрагдсан байгууллагын тоо	19	19 сумын ариутгач нарт цахим сургалтыг 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, мэдлэгийг дээшлүүлсэн. Мөн 16 сумын ариутгалын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, нийт 16 ариутгачид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.	100
11	Арга хэмжээ №2.3. Гарын эрүүл ахуй сахилтыг сайжруулах аяныг бүх шатны Эрүүл мэндийн байгууллагуудын дунд зохион байгуулах	Аян зохион байгуулах тушаал, ажлын тайлан	Үйл ажиллагааг зохион байгуулж тайлагнасан байна	ЭМГ-ын даргын 2024 оны 99 дүгээр тушаалаар эрүүл мэндийг байгууллагуудын дунд 14 хоногийн аянг өрнүүлж, 13 эрүүл мэндийн байгууллага нийт 1852 хүүхдэд	100

				гарын эрүүл ахуйн сургалтанд хамруулж, цахим сурталчилгааг нийтэлсэн. Тус эрүүл мэндийн байгууллагууд гарын эрүүл ахуйн дотоод сургалтуудыг зохион байгуулж, мэдлэгийг үнэлсэн. Боловсролын 26 байгууллагын гарын эрүүл ахуй сахиx орчин нөхцлийг үнэлж, зөвлөмж хүргүүлсэн.	
	Арга хэмжээ №2.4. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээнд халдвараас сэргийлэх, халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын үнэлгээ хийж дүгнэлт зөвлөгөө хүргүүлэх	Хяналт үнэлгээ хийсэн ЭМБ-ын тоо Холбогдох байгууллага, албан тушаалтад хүргүүлсэн зөвлөмж	Тулгамдсан асуудлыг тогтоож тайлагнасан байна. зөвлөмж гаргаж, хүргүүлсэн байна.	ЭМГ-ын даргын А/40, 101 тоот тушаалуудаар батлагдсан удирдамжийн дагуу нийт 16 сумын эрүүл мэндийн төвд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ЭМГ-ын даргын албан бичгээр хугацаатай үүрэг даалгаар өгсөн.	100
Зорилт 3. Сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд зорилтот бүлгийн иргэдийг хамруулж, өвчлөлийг эрт илрүүлж, хяналт, эмчилгээнд хамруулж, хүндрэл, тархалтаас сэргийлэх					
	Арга хэмжээ №3.1. Суманд сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ зохион байгуулах	Үзлэг хийсэн сумын тоо Үзлэгт хамрагдсан зорилтот бүлгийн тоо	Үзлэг хийсэн сумын тоо – 5 Үзлэгт хамрагдсан зорилтот бүлгийн тоо – 1000	Сүрьеэгийн эрсдэлт бүлгийн хүн амын судалгааг 2024 оны 1-р улиралд багтаан гаргаж, нийт 5805 хүний судалгаа мэдээллийг ХӨСҮТ-ийн сүрьеэгийн тандалт судалгааны албанд хүргүүлсэн. Сумдад сүрьеэ, БЗДХ-ын урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг зохион байгуулахад санхүүжилт шийдвэрлэгдэхгүй байсан тул аймгийн Засаг даргын тамгын газарт хүсэлт хүргүүлсэн боловч дэмжигдээгүй. МСЭМХ-той байгуулсан гэрээний дагуу 14 сумын ЭМТ-д дэмжлэгт хяналтыг зохион байгуулж, зөвлөмж чиглэл хүргүүлсэн.	100
13					
14	Арга хэмжээ №3.2. Сүрьеэгийн сэжигтэй тохиолдлоос сорьц авч тээвэрлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах	Идэвхжүүлэх чиглэлээр гаргасан албан бичиг	Гаргасан албан бичиг, тоот-2 Тээвэрлэсэн сорьцын тоо - 150	Эрүүл мэндийн газрын даргын албан бичгээр 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1,2-р улирлын сүрьеэгийн сорьц тээвэрлэлтийн эргэн мэдээлэл, зөвлөмжийг бүх сумын эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт хүргүүлсэн.	100

		Тээвэрлэсэн сорьцын тоо		Нийт 472 сорьц тээвэрлэснээс 16 зөрөг тохиолдол илрүүлсэн.	
15	Арга хэмжээ №3.3. Сурьвээ өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах	Сургалтын тоо Сурталчилгааны тоо	Сургалтын тоо - 2 Сурталчилгааны тоо - 2	Сурьвээгийн диспансеритай 2024 оны 3-р сарын 12-ны өдөр сумын ЭМТ-үүдийн эмч, лаборант нарт цахим сургалт зохион байгуулж, нийт 41 эмнэлгийн мэргэжилтний мэдлэгийг дээшлүүлсэн. Сурьвээтэй тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан аймгийн Нэгдсэн эмнэлгийн сурьвээгийн тасгийнхантай хамтран эмнэлгийн тусламж үйлчилгээ авч буй үйлчлүүлэгчдэд мэдээлэл өгч, 150ш гарын авлага тараасан. Мөн ЭМТ-ын цахим хуудсаар 7 төрлийн постер нийтэлсэн.	100
16	Арга хэмжээ №3.4. Бэлгийн замаар дамжих халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах	Сургалтын тоо Сурталчилгааны тоо	Сургалтын тоо - 2 Сурталчилгааны тоо - 2	ЭБС-ын 1, 2-р багийн буюу эрсдэлт бүлгийн иргэд, эмэгтэйчүүд, МСҮТ-ийн 4-н хэсгийн суралцагчдад урьдчилан сэргийлэх үзлэгийг эмчийн хамт багийн нийгмийн ажилтан, хэсгийн төлөөлөгчтэй хамтарч нийт 83 үйлчлүүлэгчид сургалт хийж, сериологийн шинжилгээ авч эмнэлзүйн эмчилгээ зөвлөгөө өгсөн. Нийт /А51,5/ оноштой-6 А54,1-3, А59,0-5, А63,0-2, бэлгийн үү-1, В37,3-8, N76,8-24, шинэ өвчлөлийг илрүүлэн эмчилсэн.	100



				 10 дугаар сарын 8,9-ны өдрүүдэд төрийн байгууллагын нийт 20 хүнд БЗДХ-ын талаар сургалт зохион байгуулсан.	
17	Арга хэмжээ №3.5. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдийн эрүүл мэндийн мэдлэгийг нэмэгдүүлэх мэдээлэл, зөвлөгөө, нийтлэл бэлтгэн түгээх	Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео, сонинд хэвлүүлсэн нийтлэл	2	Аймгийн Тамир телевизээр БЗДХ-ын нөхцөл байдал цаашид анхаарах асуудлаар ярилцлага өгсөн. Дэлхийн сүрьеэтэй тэмцэх өдрөөр АВ телевизээр сүрьеэгийн диспансери мэдээлэл өгсөн.	80
18	Арга хэмжээ №3.6. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад сургагч багш бэлтгэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг НЭМ-ийн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтран зохион байгуулах	Бэлтгэсэн сургагч багшийн тоо	Хамтран хэрэгжүүлсэн байгууллагууд – 6 Оролцсон албан хаагч 80	ЭМГ-ын даргын тушаалаар Энэ жилдээ эрүүл жиндээ 2 аяныг зохион байгуулж, нийт 4 байгууллагын 200 гаруй албан хаагчдад сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан.	100

Зорилт 4. Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх

	Арга хэмжээ № 4.1. Харшил, түүний эмчилгээ урьдчилан сэргийлэлт сэдэвт сургалтанд сумын эрүүл мэндийн төвүүдийн эмч нарыг хамруулах	Сургалтанд хамрагдсан эмч нарын тоо	25	Анафилактик шокийн үед яаралтай тусламж үзүүлэх сургалтыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасагтай хамтран 54 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэгийг дээшлүүлсэн. Арьс өвчин судлалын үндэсний төвтэй хамтран 2024 оны 5-р сарын 22-нд сумын эрүүл мэндийн төвүүдийн нийт 36 эмч мэргэжилтнүүдэд цахимаар сургалтанд хамруулж, мэдлэгийг дээшлүүлсэн.	100
20	Арга хэмжээ № 4.2. Харшил төрүүлэгч ургамлын агаар дахь тоосжилтын хуанлийг боловсруулж, орон нутгийн ТВ-ын мэдээгээр сар бүр, ЭМГ-ын	Мэдээлсэн тайлан	Орон нутгийн ТВ-ын мэдээгээр сар бүр, ЭМГ-ын	Харшил төрүүлэгч ургамлын агаар дахь тоосжилтын хуанлийг Эрүүл мэндийн газрын фэйсбүүк пэйж хуудас болон сүм, өрхийн	100

	болон ЭМБ-ын цахим хуудсаар 7 хоног бүр мэдээлдэг болох		болон ЭМБ-ын цахим хуудсаар 7 хоног бүр мэдээлсэн тайлан	ЭМТ-үүдийн цахим хуудсаар 6-9 сард тогтмол олон нийтэд түгээсэн.	
	Арга хэмжээ № 4.3. Хүн амын суурьшлын газар дахь шарилж, хөл газрын ургамлыг 6, 7, 8 сард тайралт хийж, ургамлын тоосонцрын сөрөг үр дагаврыг бууруурах үйл ажиллагааг зохион байгуулах	Зохион байгуулсан ажлын удирдамж, тайлан	Үйл ажиллагааны удирдамж, явцын тайлан	Ногоон байгууламж дахь харшил үүсгэгч ургамлын тоос, үр боловсрохоос өмнө батлагдсан аргачлалын дагуу тайралт хийх тухай албан бичгийг сумын Засаг дарга нарт хүргүүлсэн. Сумын эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан айл өрхийг ногоон байгууламжтай болох уриалга гарган, 8 сумын 250 гаруй өрх ногоон байгууламжтай болж, 19 сумын эрүүл мэндийн төвүүд шарилж, харшил үүсгэгч ургамлыг бууруулах сурталчилгааг 1200 гаруй иргэдэд хүргэж, мэдлэгийг дээшлүүлсэн.	100
21					
22	Арга хэмжээ № 4.4. ЕБС-ийн эрүүл мэндийн багш нарт харшлын өвчнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах сэдвээр цахим сургалт зохион байгуулах	Сургалтанд хамрагдсан сургуулийн тоо	20 -	ЕБС-ийн эрүүл мэндийн багш нарт харшлын өвчнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах сэдэвт чадавхижуулах сургалтыг цахимаар зохион байгуулж, нийт 41 багшийн мэдлэгийг дээшлүүлсэн.	100
23	Арга хэмжээ № 4.5. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд харшил үүсгэгч хүнсний бүтээгдэхүүн, шошго, тэмдэг тэмдэглэгээний талаар сургалт зохион байгуулах	Боловсруулсан сургалтын хөтөлбөр, хичээл, Сургалтад хамрагдсан хүний тоо	Сургалтын хөтөлбөр, хичээлийг боловсруулсан байна. Сургалтад хамрагдсан хүний тоо-20	Хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодлын шошгологтыг зөв таних, шошгын тэмдэглэгээ, хүнсний бус хуванцар савны хор уршиг, ундны усны зориулалтын савны талаарх 4 төрлийн зөвлөмжийг Эрүүл мэндийн газар, анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд цахим хуудсанд байршуулж, 3000 гаруй иргэн хандаж мэдээлэл авсан.	80
Зорилт 4. Төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлэх					

24	Арга хэмжээ № 5.1. Эрүүл мэндийн байгууллагуудад дэмжлэгт хяналт хийж, мэргэжил аргагүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж хүргүүлэх, гүйцэтгэлийн хяналт хийх	Дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж хүргүүлсэн байгууллагын тоо	Сумын ЭМТ-3	2 өрхийн эрүүл мэндийн төвд үнэлгээ хийж, гарсан алдаа зөрчилд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргасан шүдний эмнэлэг, эмийн сангуудын ажлын байранд үнэлгээ хийсэн. 16 сумын ЭМТөвд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	100
25	Арга хэмжээ № 5.2 ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хугацаатай албан бичиг, цаг үеийн ажил, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх;	Сар, улирал, жилийн эцсийн тайлан, хугацаатай албан бичиг, цаг үеийн ажил, бусад тайлан мэдээллийг хугацаанд нь журмын дагуу тайлагнасан хувь	100	Сар, улирлын тайлан, нийт 17 хугацаатай албан бичиг, цаг үеийн ажил, бусад тайлан мэдээллийг хугацаанд нь журмын дагуу 100% тайлагнасан.	100

ГУРАВ. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Үнэлгээ
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	
1	Судалгааны үр дүнг боловсруулах SPSS програмыг цахимаар сурах	Програм ашиглалтын хувь	Програмыг цахимаар суралцаж, ЕБС-аас авсан судалгааны боловсруулалтын тус программ дээр хийсэн.	100

2410

96.4

ТАЙЛАН БИЧСЭН:

ОРЧНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
(Албан тушаал)

 / Г. АРИУНТУЯА /
(Нэр, зарын үсэг)

2024.12.12
(Огноо)

ТАЙЛАНГ ҮНЭЛСЭН:

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
(АЛБАН ТУШААЛ)

 / Г. АРИУН-ЭРДЭНЭ /
(ГАРЫН ҮСЭГ)

ОГНОО: 2024.12.14